



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 10 сарын 08 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны “Төрийн өмчийн үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн дуудлагын худалдааны талаар авах зарим арга хэмжээний тухай” 268 дугаар тогтоолын 4.2, 4.3 дахь заалт, “Мэдээ тайлангийн маягт батлах тухай” 269 дүгээр тогтоолын 2, 3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Үндэсний аудитын газрын харьяа Архангай, Баян-Өлгий, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 156,647,000.00 /нэг зуун тавин зургаан сая зургаан зуун дөчин долоон мянган/ төгрөгийн балансын үнэ бүхий 4 ширхэг автомашиныг нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрч, худалдах доод үнийг хавсралтад заасны дагуу тогтоосугай.

2.Үндэсний аудитын газрын Тамгын газрын дарга Ц.Ганболд, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Үндсэн хөрөнгийг дуудлагын худалдаагаар худалдах ажлыг холбогдох хууль тогтоомж, захиргааны актын дагуу зохион байгуулах;

2.2.Дуудлагын худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх;

2.3.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4.Энэ тогтоолын биелэлтийг холбогдох мэдээ тайлангийн маягт, хөрөнгийн үнийг төвлөрүүлсэн баримт, автомашиныг улсын бүртгэлээс хасуулсан тодорхойлолтыг 2020 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2020 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн
484 дугаар тогтоолын хавсралт

Үндэсний аудитын газрын харьяа Архангай, Баян-Өлгий, Баянхонгор аймаг дахь
Төрийн аудитын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй нээлттэй дуудлагын
худалдаагаар худалдах автомашины жагсаалт

Д/д	Автомашины марк, улсын дугаар, арал	Үйлдвэрлэсэн, ашиглалтад орсон он	Гүйлт, км (мянга)	Балансын үнэ (төгрөг)	Хуриутлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээгч босголт (төгрөг)	Худалдах доод үнэ (төгрөг)	Балансад бүртгэлтэй байгууллага
1	Ландкрудер-80, 56-28 АРА, арал№FZJ800155228	1996/ 2008	15231	23,301,000.00	23,301,000.00	0	0	1,000,000.00	Архангай Төрийн аудитын газар
2	Ландкрудер-100, 05-20 УБЗ, арал№JTECB01J40100 5755	2002/ 2002		79,596,000.00	79,596,000.00	0	0	2,000,000.00	Архангай Төрийн аудитын газар
3	Ландкрудер-80, 01-38 БӨА, арал№JT3HJ85JXT014 0081	1996/ 2011	845625	35,000,000.00	35,000,000.00	0	0	1,000,000.00	Баян-Өлгий Төрийн аудитын газар
4	УАЗ-220692-033, 80-08 БНХ, арал№374100C0483483	2012/ 2012		18,750,000.00	18,750,000.00	0	0	500,000.00	Баянхонгор Төрийн аудитын газар
	Нийт дүн			156,647,000.00 /нэг зуун тавин зургаан сая зургаан зуун дөчин долоон мянган/	156,647,000.00 /нэг зуун тавин зургаан сая зургаан зуун дөчин долоон мянган/	0	0	4,500,000.00 /дөрвөн сая таван зуун мянган/	